


БҮЛЭГ 6. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ХҮЙСИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ⁵

Энэ бүлэгт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхийг харьцуулж судлана. Эдийн засгийн идэвхийн мэдээллийг тооллогын өмнөх долоо хоногт хийсэн ажлын төрөл, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажил эрхлэлтийн байдал, эдийн засгийн идэвхигүй хүмүүсээс ажил хийгээгүй шалтгаан зэрэг багц асуултаар авсан.

6.1 Ойлголт, тодорхойлолт

Зураг 6.1-д 2000 оны хүн ам, орон сууцны тооллогод хэрэглэсэн эдийн засгийн идэвхийн ойлголт, тодорхойлолтыг харуулав. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолтын талаархи мэдээлэл Хавсралт 1-ийн Хүснэгт 1-д байгаа.

Зураг 6.1 Эдийн засгийн идэвхийн ойлголт, 2000*



* 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын тайлан: Үндсэн үр дүн, ҮСГ, НҮБ-ын ХАС, 2001. хуудас 82.

Зураг 6.1-д үзүүлсний дагуу 15, түүнээс дээш насны хүн амыг ажиллах хүч, эдийн засгийн идэвхигүй хүн ам гэж хоёр хувааж болно. Ажиллах хүч нь ажиллагсад, ажилгүйчүүд буюу ажил хайж байгаа хүмүүс гэж хоёр хуваагдаж байхад эдийн засгийн идэвхигүй хүн ам нь тохирох ажил олдохгүй, оюутан, тэтгэвэрт гарсан, тахир дутуу, гэрийн ажилтай болон бусад гэж хуваагдаж байна. Тухайн хүн тооллогын өмнөх долоо хоногт ядаж нэг цаг цалин хөлстэй ажил эрхэлсэн бол түүнийг ажил эрхэлж байгаа гэж үзсэн.

⁵ Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр эдийн засгийн идэвхийн талаар илүү нарийвчилсан судалгаа удахгүй хэвлэгдэн гарна.

6.2 Эдийн засгийн идэвхийн төрх, байдал, хүйсээр

15, түүнээс дээш насны хүн амын 61.9 хувь нь ажиллах хүчинд багтаж, хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин (68.6 хувь) эмэгтэйчүүдийнхээс (55.5 хувь) өндөр байна. Хөдөөд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин (80.1 хувь) эмэгтэйчүүдийнхээс (66.9 хувь) дээгүүр байна. Хотод эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хөдөөгийнхөөс доогуур (60.2 хувь) гэхдээ хотын эмэгтэйчүүдийнхээс (47.9 хувь) өндөр байна.

Хүснэгт 6.1 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, хүйс, байршлаар, 2000 оны тооллогоор

Эдийн засгийн идэвхийн байдал	Хот			Хөдөө			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажиллах хүч	60.2	47.9	53.8	80.1	66.9	73.6	68.6	55.5	61.9
Эдийн засгийн идэвхигүй	39.8	52.1	46.2	19.9	33.1	26.4	31.4	45.5	38.1


Эдийн засгийн идэвхигүй байгаа шалтгааныг хүйсээр харьцуулж үзэхэд нилээд ялгаатай байна. Эрэгтэйчүүдийн дийлэнхи нь (30.2 хувь) оюутан, 22.9 хувь нь тэтгэвэрт гарсан байна. Харин эмэгтэйчүүдийн 31.9 хувь нь тэтгэвэрт гарсан байхад 28.9 хувь нь сургуульд сурч байна. Эмэгтэйчүүдийн тавны нэг нь (19.0 хувь) гэрийн ажилтай байна (Хүснэгт 6.2). “Тохирох ажил олдохгүй”, “бусад” гэсэн шалтгааны улмаас ажил хийгээгүй эрэгтэйчүүдийн эзлэх хувь (22.6 хувь, 11.0 хувь), эмэгтэйчүүдийнхээс (11.0 хувь, 4.7 хувь) хоёр дахин их байна. Энэ нь өмнө мөрдөгдөж байсан эрэгтэйчүүд (60 нас), эмэгтэйчүүдийн (55 нас) тэтгэврийн насны ялгаанаас зарим талаар холбоотой.

Хүснэгт 6.2 Эдийн засгийн идэвхигүй байгаа шалтгаан, хүйсээр, 2000 оны тооллогоор

Шалтгаан	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	235.7	344.6	580.3
Тохирох ажил олдохгүй	22.6	10.8	15.6
Оюутан	30.2	28.9	29.4
Тэтгэвэрт, нөхөн олговорт	22.9	31.9	28.2
Тахир дутуу	8.7	4.7	6.4
Гэрийн ажилтай	4.6	19.0	13.2
Бусад	11.0	4.7	7.2

Ажиллах хүчний оролцооны түвшинг насны бүлгээр авч үзэхэд 20-49 насанд харьцангуй тэгшхэн, түүнээс дээш насанд буурсан муруй шугаман төрх байдал харагдаж байна (Зураг 6.2). Энэ насны бүлэгт хүйсээр ялгаа бага байхад 40, түүнээс дээш насанд ялгаа мэдэгдэхүйц нэмэгдэж, эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс дээгүүр байна.

Зураг 6.2 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000 оны тооллогоор



6.3 Ажил эрхлэлт, насны бүлэг, байршлаар

Ажиллагсадад тооллогын өмнөх долоо хоногт ажил эрхэлсэн, эсвэл улирлын чанартай ажил эрхэлдэг, өвчтэй, амралттай байсны улмаас ажлаас түр хугацаагаар чөлөөлөгдсөн бүх хүмүүс орж байна. Ажил эрхэлж байгаа бүх хүмүүсээс тэдний ажлын талаар эрхэлж байгаа ажил, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажил эрхлэлтийн байдал гэсэн гурван асуулт асуусан.

Хүснэгт 6.3 15, түүнээс дээш насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хүйс, байршлаар, 2000 оны тооллогоор

Хүйс	Хот	Хөдөө	Бүгд
Бүгд	40.7	66.1	51.1
Эрэгтэй	44.5	72.0	56.1
Эмэгтэй	37.2	60.1	46.3

2000 оны тооллогоор 15, түүнээс дээш насны хүн амын талаас илүү хувь нь (51.1 хувь) ажил эрхэлж байна (Хүснэгт 6.3). Гэхдээ хот, хөдөөд нилээд ялгаатай байна. Хөдөөд 15, түүнээс дээш насны хүн амын гуравны хоёр нь (66.1 хувь), хотод 40.7 хувь нь ажил эрхэлж байна. Хөдөөд ажил эрхлэлт өндөр байгаа нь хөдөө аж ахуйн ажлын онцлогтой холбоотой. Ажил эрхлэлт хүйсээр ялгаатай байна. Ажил эрхэлдэг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 9.8 пунктээр илүү байна. Энэ ялгаа хөдөөд (11.9 пункт) хотоос (7.3 пункт) илүү байна.

6.4 Эдийн засгийн идэвхи

Хүн амыг эдийн засгийн идэвхийн байдлаар ажиллах хүч, эдийн засгийн идэвхигүй хүн ам гэж хоёр хувааж тооцсон ажиллах хүчний оролцооны коэффициент 35-44 насанд хамгийн өндөрт хүрч дараа нь буурч байна. 20-24 насны хүн амын гуравны нэгээс илүү (67.7 хувь) нь ажиллах хүчинд багтаж

байна. Харин 55-59 насанд дөнгөж 41.8 хувь нь ажиллах хүчинд байна. Энэ насанд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны коэффициент эмэгтэйчүүдийнхээс гурав дахин өндөр байна. Энэ нь эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах нас (55 нас) эрэгтэйчүүдийнхээс (60 нас) залуу байснаас шалтгаалж байна. 35-44 насанд эрэгтэйчүүдийн 81.7 хувь, эмэгтэйчүүдийн 79.3 хувь нь ажиллах хүчинд багтаж байна. 55-59 насанд эрэгтэйчүүдийн 62.0 хувь ажиллах хүчинд багтаж байхад эмэгтэйчүүдийнх дөнгөж 22.3 хувь байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны коэффициент 45 наснаас эхлээд буурч байна.

Хүснэгт 6.4 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, насны бүлэг, хүйсээр, 2000 оны тооллогоор

Насны бүлэг	Ажиллах хүч			Эдийн засгийн идэвхитэй хүн ам		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	68.6	55.5	61.9	31.4	44.5	38.1
15-19	48.0	34.4	41.2	52.0	65.6	58.8
20-24	74.5	60.8	67.7	25.5	39.2	32.3
25-34	81.0	72.0	76.5	19.0	28.0	23.5
35-44	81.7	76.3	78.9	18.3	23.7	21.1
45-54	77.1	53.3	64.9	22.9	46.7	35.1
55-59	62.0	22.3	41.8	38.0	77.7	58.2
60+	17.7	8.0	12.3	82.3	92.0	87.7

6.5 Ажил эрхлэлт, нас, хүйсээр


Ажил эрхэлж байгаа эрэгтэйчүүдийн бараг гуравны нэг нь (31.2 хувь) 25-34 насныхан байхад эмэгтэйчүүдийн 33.8 хувь нь ийм насных байна. Ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн аравны нэг нь (9.1 хувь) 15-19 насныхан байна. 45-54 насныхан мөн аравны нэг (эрэгтэйчүүд 11.1 хувь, эмэгтэйчүүд 10.1 хувь) болж байна.

Хүснэгт 6.5 15, түүнээс дээш насны ажил эрхэлж байгаа хүн ам, дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2000 оны тооллогоор

Насны бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0
15-19	11.5	9.1	10.4
20-24	16.4	15.9	16.2
25-34	31.2	33.8	32.4
35-44	23.8	27.8	25.6
45-54	11.1	10.1	10.6
55-59	3.8	1.8	2.9
60+	2.3	1.5	2.0

Тухайн насны бүлгийн хүн амд ажил эрхэлж байгаа хүний эзлэх хувийг судлахад ажил эрхлэлт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь 40-49 насанд хамгийн өндөр байна. Ажил эрхлэлтийн бууралт эмэгтэйчүүдийн хувьд арай эрт эхэлж, 50-59 насанд гучаас ялимгүй илүү хувь нь ажил эрхэлж байснаа мэдэгдэхүйц буурч 60, түүнээс дээш насанд 10.0 хүрэхгүй хувь ажил эрхэлж байна. Энэ нь эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гардаг нас (55 нас) эрэгтэйчүүдийнхээс (60 нас) арай эрт байдгаас зарим талаар шалтгаалж байна.

Зураг 6.3 15, түүнээс дээш насны хүн амд ажил эрхэлж байгаа хүн амын эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2000 оны тооллогоор



6.6 Ажил эрхлэлтийн байдал

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдлыг харьцуулж судлахад эрэгтэйчүүдийн дийлэнхи нь хувиараа ажиллагч (43.9 хувь), эсвэл гэрээгээр ажиллагч (39.3 хувь) байна. Харин эмэгтэйчүүдийн дийлэнхи нь гэрээгээр ажиллагч (43.6 хувь) эсвэл гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч (38.6 хувь) байна. Ажил эрхлэлтийн байдал хүйсээр мэдэгдэхүйц ялгаатай байна. 2000 оны тооллогод ихэнхи малчин өрхийг биеэ даасан эдийн засгийн нэгж гэж үзсэн юм. Энэ нэгжид ихэнхи тохиолдолд нөхрийн ажил эрхлэлтийн байдал хувиараа ажиллагч, эхнэрийн ажил эрхлэлтийн байдал нь гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч болж орсон юм.

Хүснэгт 6.6 15, түүнээс дээш насны ажил эрхэлж байгаа хүн ам, ажил эрхлэлтийн байдал, дүнд эзлэх хувиар, хүйсээр, 2000 оны тооллогоор

Ажил эрхлэлтийн байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0
Ажиллагсадын тоо	420426	358725	779151
Гэрээгээр ажиллагч	39.3	43.6	41.3
Ажил олгогч	1.7	0.8	1.3
Хувиараа ажил эрхлэгч	43.9	16.3	31.7
Хоршооллын гишүүн	0.5	0.5	0.5
Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч	14.0	38.6	25.3
Бусад	0.6	0.2	0.4

6.7 Эрхэлдэг ажлын хүйс, байршлаар ялгаатай байдал

Ажил эрхэлж байгаа хүн амыг эрхэлж байгаа ажлаар судлахад (Хүснэгт 6.7) дийлэнхи нь (бүгд 46.2 хувь, эрэгтэйчүүд 47.3 хувь, эмэгтэйчүүд 44.9 хувь) хөдөө аж ахуйн мэргэшсэн ажиллагсад байна. Эрэгтэйчүүдийн хувьд дараагийн хамгийн том бүлэг нь машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч

(11.3 хувь), эмэгтэйчүүдийн хувьд мэргэжилтэн (13.7 хувь), үйлчилгээний ажилтан (12.4 хувь) байна.

Эрхэлдэг ажлыг хот, хөдөөгөөр судлахад нэлээд ялгаатай байгаагийн дотор хотод мэргэжилтэн, үйлчилгээний ажилтан, үйлдвэрийн ба худалдааны ажилчин зэрэг ажил зонхилж байна. Хотод эрэгтэйчүүдийн 10.7 хувь нь хууль тогтоогч, ахлах ажилтан, менежер байхад ийм ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүд үүний бараг тал нь (5.5 хувь) байна. Харин мэргэжилтэн хийж байгаа эмэгтэйчүүд харьцангуй олон байна. Хотод эмэгтэйчүүдийн бараг дөрөвний нэг нь (23.0 хувь) мэргэжилтэн байхад эрэгтэйчүүдийн 11.3 хувь мэргэжилтэн байна. Үйлчилгээний ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс хоёр дахин олон байхад үйлдвэрийн ба худалдааны ажилчин, машин тоног, төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажилд эрэгтэйчүүд давамгайлж байна. Хөдөөд “цагаан ажил” (хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер, инженер техникийн ажилтан, туслах ажилтан) эрхэлж байгаа эрэгтэйчүүд 6.1 хувь байгаа нь эмэгтэйчүүдээс (10.1 хувь) доогуур байна. Мэргэжилтнээр ажиллаж байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс олон байна.

Хотод ажил эрхэлж байгаа хүмүүсийн 11.1 хувь нь гудамжинд худалдаа хийх, манаач, цэвэрлэгээ, хувцас угаалга зэрэг энгийн ажил эрхэлж байна. Хотод эрхэлж байгаа ажил хүйсээр нилээд ялгаатай байна. Харин хөдөөд энэ ялгаа бараг алга. Хөдөөд эрэгтэйчүүдийн 80.7 хувь, эмэгтэйчүүдийн 81.0 хувь хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтнаар ажиллаж байна.

Эмэгтэйчүүд хэдийгээр ажил эрхлэлтийн ангилалын мэргэжилтний бүлэгт давамгайлж байгаа ч тэд ангилалын доод, дунд түвшинд давамгайлж, харин эрэгтэйчүүд дээд түвшинд, өөрөөр хэлбэл, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах түвшинд зонхилж байна.

Хүснэгт 6.7 15, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эрхэлдэг ажил, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 оны тооллогоор

Эрхэлдэг ажил	Ажиллагсад			Хот			Хүй- сийн ялгаа	Хөдөө			Хүй- сийн ялгаа
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд		Эр	Эм	Бүгд	
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0		100.0	100.0	100.0	
Ажиллагсaдын тоо	420426	358725	779151	193000	173044	366044		227426	185681	413107	
Хууль тогтоогч, төрийн болон төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер	6.4	3.2	4.9	10.7	5.5	8.2	-5.2	2.8	1.2	2.0	-1.6
Мэргэжилтэн	6.2	13.7	9.6	11.3	23.0	16.8	11.7	1.8	4.9	3.2	3.1
Инженер, техникийн ажилтан	2.9	6.6	4.6	5.1	10.6	7.7	5.5	1.0	2.8	1.8	1.8
Туслах ажилтан	1.0	3.4	2.1	1.6	5.8	3.6	4.2	0.5	1.2	0.8	0.7
Үйлчилгээний ажилтан, дэлгүүр, зах дээр худалдаа эрхлэгч	5.9	12.4	8.9	10.9	20.7	15.5	9.8	1.6	4.7	3.0	3.1
Хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилчин	47.3	44.9	46.2	8.0	6.2	7.1	-1.8	80.7	81.0	80.8	0.4
Гар урлал, бусад холбогдох ажил	9.4	6.9	8.3	17.9	13.0	15.6	-4.9	2.3	1.3	1.8	-2.0
Машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	11.3	1.2	6.7	17.8	2.2	10.4	-15.6	5.8	0.3	3.3	-5.5
Энгийн ажил	6.1	6.4	6.3	11.1	10.6	10.9	-0.5	1.9	2.5	2.2	-0.6
Бусад	3.5	1.2	2.5	5.6	2.5	4.1	-3.1	1.7	0.1	1.0	-1.6

6.8 Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, нас, хүйсээр

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбарыг авч үзэхэд ажиллагсадын олонхи нь (47.2 хувь) хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй салбарт ажиллаж энэ салбар давамгайлж байна. Хотод боловсруулах үйлдвэр, бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газар, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ зэрэг үйл ажиллагаанд эмэгтэйчүүд давамгайлж байхад уул уурхай, олборлох үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаанд эрэгтэйчүүд давамгайлж байна. Бусад салбарт ажиллагсадын хүйсийн ялгаа бага байна (Хүснэгт 6.8).

Хүснэгт 6.8 15, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хүйс, байршлаар, 2000 оны тооллогоор

Эдийн засгийн үйл ажиллаганы үндсэн чиглэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажиллагсадын тоо	420426	358725	779151	193000	173044	366044	227426	185681	413107
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	48.7	45.4	47.2	8.8	6.4	7.7	82.6	81.7	82.2
Уул уурхай, олборлох үйлдвэр	3.4	1.3	2.4	5.9	2.3	4.2	1.2	0.4	0.8
Боловсруулах үйлдвэр	6.1	8.6	7.3	11.7	16.5	13.9	1.4	1.3	1.4
Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	2.9	1.1	2.0	5.4	2.1	3.8	0.7	0.1	0.5
Барилга	2.4	1.0	1.8	5.0	1.9	3.6	0.2	0.1	0.2
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа	7.9	9.8	8.8	15.2	17.0	16.1	1.7	3.1	2.3
Зочид буудал, зоогийн газар	0.8	2.2	1.4	1.5	4.1	2.7	0.2	0.4	0.3
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	7.2	3.3	5.4	12.6	6.0	9.5	2.6	0.8	1.8
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0.4	0.7	0.6	0.8	1.2	1.0	0.1	0.3	0.2
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	1.3	1.3	1.3	2.6	2.5	2.6	0.2	0.3	0.2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгалын үйл ажиллагаа	10.2	4.6	7.7	16.1	7.2	11.9	5.3	2.2	3.9
Боловсрол	3.5	10.2	6.6	5.3	15.0	9.9	2.0	5.8	3.7
Эрүүл мэнд, нийгмийн халамж	1.5	6.8	3.9	2.1	10.9	6.2	0.9	3.1	1.9
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	2.4	2.2	2.3	4.4	4.2	4.3	0.7	0.4	0.5
Бусад	1.3	1.4	1.3	2.8	2.7	2.8	0.1	0.1	0.1

6.9 Ажил эрхлэлтийн аймаг, хүйсээр ялгаатай байдал

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг аймгаар авч үзэхэд ажил эрхлэлтийн түвшин Дорнод аймагт хамгийн бага буюу 68.8 хувь, Өмнөговь аймагт хамгийн их буюу 92.5 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 6.9). Ажил эрхлэлтийн түвшин өндөр байгаа аймагт Дундговь (92.0 хувь), Баянхонгор (89.4 хувь), Архангай (89.3 хувь) орж байна. Улаанбаатар хот үйлчилгээний салбарт ажиллах боломж хамгийн өндөртэй газар боловч ажил эрхлэлтийн түвшин 79.8 хувь байгаа олонхи аймгаас доогуур байна. Энэ нь аймаг, нийслэлд эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын эзлэх хувь их өөр, аймгуудад хөдөө аж ахуйн салбар зонхилох байр суурь эзэлж байгаатай холбоотой. Гэхдээ аймгуудын ажил эрхлэлтийн түвшин өндөр байгаа нь

ажиллагсадын ихэнхи нь мал аж ахуйд ажиллаж байгаатай холбоотой. Эрэгтэйчүүдийн дунд ажил эрхлэлтийн түвшин хамгийн бага нь Дорнод аймагт (70.4 хувь) хамгийн өндөр нь Дундговь (92.3 хувь), Өмнөговь (92.3 хувь) аймагт байна. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин Дорнод аймагт хамгийн бага буюу 66.9 хувь, Өмнөговь аймагт хамгийн өндөр буюу 92.8 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 6.9)

Хүснэгт 6.9 15, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, ажилгүйчүүд, хүйс, аймгаар, дүнд эзлэх хувиар, 2000 оны тооллогоор

Аймаг, нийслэл	Бүгд			Эрэгтэй			Эмэгтэй		
	Бүгд	Ажил-лагсад	Ажил-гүйчүүд	Бүгд	Ажил-лагсад	Ажил-гүйчүүд	Бүгд	Ажил-лагсад	Ажил-гүйчүүд
Бүгд	944083	82.5	17.5	514196	81.8	18.2	429887	83.4	16.6
Архангай	40733	89.3	10.7	22146	88.9	11.1	18587	89.8	10.2
Баян-Өлгий	32906	80.0	20.0	18731	81.0	19.0	14175	78.7	21.3
Баянхонгор	37657	89.4	10.6	19832	88.6	11.4	17825	90.4	9.6
Булган	26313	82.1	17.9	14564	81.9	18.1	11749	82.2	17.8
Говь-Алтай	29946	88.9	11.1	15751	88.8	11.2	14195	89.0	11.0
Дорноговь	23038	86.3	13.7	13022	87.4	12.6	10016	84.8	15.2
Дорнод	26620	68.8	31.2	14829	70.4	29.6	11791	66.9	33.1
Дундговь	24135	92.0	8.0	12749	91.8	8.2	11386	92.3	7.7
Завхан	39553	84.6	15.4	21539	84.4	15.6	18014	84.8	15.2
Өвөрхангай	51259	89.0	11.0	27296	88.8	11.2	23963	89.2	10.8
Өмнөговь	22410	92.5	7.5	11923	92.3	7.7	10487	92.8	7.2
Сүхбаатар	24494	81.9	18.1	13714	83.5	16.5	10780	79.9	20.1
Сэлэнгэ	35873	70.7	29.3	20745	71.3	28.7	15128	69.8	30.2
Төв	42575	82.7	17.3	24540	83.6	16.4	18035	81.6	18.4
Увс	35462	85.3	14.7	19855	85.2	14.8	15607	85.3	14.7
Ховд	33321	88.4	11.6	18729	87.4	12.6	14592	89.6	10.4
Хөвсгөл	51041	87.3	12.7	27523	86.4	13.6	23518	88.3	11.7
Хэнтий	29114	81.2	18.8	15999	81.5	18.5	13115	80.8	19.2
Дархан-Уул	29742	73.9	26.1	16032	72.8	27.2	13710	75.1	24.9
Улаанбаатар	275016	79.8	20.2	146858	77.2	22.8	128158	82.8	17.2
Орхон	28321	73.1	26.9	15309	73.3	26.7	13012	72.9	27.1
Говьсүмбэр	4554	80.8	19.2	2510	81.2	18.8	2044	80.2	19.8

6.10 Өндөр боловсролтой хүмүүсийн ажилгүйдлийн түвшин

2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс ажилгүйдлийн түвшинг тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, мөн дээд боловсролтой ажилгүйдчүүдээр аймгаар харьцуулж үзэхэд Дорнод, Хэнтий аймагт ажилгүйдчүүдийн дунд боловсролын түвшин хамгийн бага буюу 7.2 хувь, Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 18.2 хувийн хооронд хэлбэлзэж байна. Дээд боловсролтой эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс бүх аймагт өндөр байв. Ажилгүйдлийн хамгийн өндөр хувь шилжих хөдөлгөөнөөр хамгийн олон хүн хүлээн авч байгаа Улаанбаатар хотод байна (Хүснэгт 6.10). Улаанбаатар хотын тав, түүнээс дээш насны хүн амын 13.7 хувь тооллогын өмнөх таван жилд (1995-2000) шилжин иржээ. (Хүснэгт 7.4-ийг харна уу). Эндээс үзэхэд шилжих хөдөлгөөн, ажил эрхлэлтийг нарийн холбож судлах нь чухал байна.

Хүснэгт 6.10 Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, дээд боловсролтой
ажилгүйчүүд, аймаг, хүйсээр, 2000 оны тооллогоор

Ажилгүйчүүд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	10.1	16.1	12.7
Тоо	9478	11456	20934
Архангай	7.7	14.6	10.7
Баян-Өлгий	12.9	16.3	14.5
Баянхонгор	7.4	10.2	8.6
Булган	5.6	10.3	7.7
Говь-Алтай	7.8	14.1	10.8
Дорноговь	6.1	15.0	10.4
Дорнод	5.5	9.1	7.2
Дундговь	7.4	13.8	10.3
Завхан	8.2	15.6	11.5
Өвөрхангай	7.9	11.0	9.3
Өмнөговь	8.1	14.2	10.8
Сүхбаатар	6.2	8.7	7.5
Сэлэнгэ	5.2	11.0	7.7
Төв	5.4	10.4	7.6
Увс	7.4	14.0	10.3
Ховд	10.2	15.8	12.4
Хөвсгөл	7.3	12.6	9.5
Хэнтий	5.8	8.9	7.2
Дархан-Уул	8.6	15.9	11.8
Улаанбаатар	14.7	23.5	18.2
Орхон	10.9	17.8	14.1
Говьсүмбэр	7.6	12.1	9.7